

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ХАМТАРСАН БАГ БАЙГУУЛАХ, ОЙЛГОЛТ НЭГТГЭХ

Алхам 1: Сургуулийн хамт олонд мэдээлэл өгөх

Сургуулийн удирдлагуудтай уулзан, аргачлалаа танилцуулна. Хамт олонд тухайлбал, багш, ажилчдын хурал дээр 30 минутанд багтаанд аргачлалын зорилго, зарчмыг танилцуулна. Мөн эцэг эх, сурагчийн төлөөлөлд танилцуулж, хамтран ажиллах хүсэлтийг тавина.

Алхам 2: Хамтарсан баг байгуулах

Сайн сургуулийг хэрэгжүүлэхэд суралцах сургалтанд оролцсон гишүүд зохион байгуулж, хамтарсан багаа байгуулна. Багт 10-15 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хамтарсан багийг байгуулахад дараах бүлгийн төлөөллийг аль болох бүрэн хангахыг хичээгээрэй. Мөн асуулга, бүлгийн ярилцлага зохион байгуулахад оролцогчдыг сонгохдоо эдгээр төлөөллийг заавал оролцуулахад анхаарна уу. Үүнд:

- Сурагчид – дотуур байрны, СӨУБ, ахлах дунд, 4-5 хүүхэд байна. Хүйсийн тэнцвэрийг хангахад анхаарна.
- Эцэг эх – малчин, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнхийн төлөөллийг хангахад анхаарна.
- Багш, захиргааны болон аж ахуй, үйлчилгээний ажилтан – бага, дунд, ахлах ангийн багш нарын төлөөллийг нас, ажлын туршлага, хүйсийн хүйсийн тэнцвэртэйгээр оролцуулна.
- Орон нутгийн засаг захиргаа – боловсрол хариуцсан хэлтэс, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн байцаагч, боловсролын хэлтсийн төлөөлөл зэргээс оролцуулахыг хичээнэ.
- Иргэний нийгмийн байгууллага, бүлгүүд – жишээлбэл, хүүхдийн эрх болон боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажилладаг төрийн бус байгууллага, бүлгүүд буюу ашиг сонирхлоороо нэгдэн үйл ажиллагаа явуулж буй иргэд байна.
- Түншлэгчид, гэрээлэгчид – орон нутагт боловсролын чиглэлээр ажилладаг олон улсын байгууллага, тухайн сургуультай хамтран ажилладаг иргэн, аж ахуйн нэгж зэрэг төлөөлөл байж болно.

Ийнхүү хамтарсан багийг олон талын төлөөлөлтэйгээр байгуулсны дараа багаараа зорилго, зарчим, үнэт зүйлсээ нэг бүрчлэн ярилцаж ойлголцно.

Алхам 3: Ойлголт нэгтгэх семинар зохион байгуулах

Хамтарсан багийн гишүүдийг албан ёсоор цуглуулан аргачлалыг хэрэгжүүлэх зорилго, ач холбогдлын талаар болон ойлголтоо нэгтгэх хагас өдрийн семинар зохион байгуулна. Семинарыг багийн гишүүдийн цаг зав, ажлын боломжинд тааруулан зохион байгуулах тодорхой цаг товлож, дараагийн хуудсанд тодорхойлсон загвар хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

Алхам 4: Хамтарсан багийн ажлын төлөвлөгөө гаргах

Аргачлалыг хэрэгжүүлэх хугацаа, ажил үүргийн хуваарийг багаараа төлөвлөнө. Хамтарсан багаар явцын уулзалтыг 2-3 удаа зохион байгуулах нь үр дүнтэй байдаг. Жишээлбэл, багаараа сургууль, дотуур байраар явж ажиглалт хийх, баримт бичгийн дүн шинжилгээ хийх, асуулга, ярилцлага хийх гишүүд асуултуудаа ярилцаж ойлголтоо нэгтгэх зэргээр хариуцсан ажлын дагуу уулзах хэрэгтэй.

Семинарын бэлтгэлээ шалгах хуудас:

- Хамтарсан багийн гишүүдэд эхний семинар хэзээ, хаана, хэдэн цагт болох тухай мэдээлэл өгнө.
- Семинар хийх анги танхимаа сургуулийн удирдах ажилтнуудтай урьдчилан ярилцаж бэлдсэн байна.
- Сургалтын үеэр хэрэглэгдэх материалуудыг жагсаан бичиж бэлдэнэ (компьютер, дэлгэц, чанга яригч, “Сайн сургуулийг бүтээцгээе!” залуусын кино, самбарын цаас, өнгийн харандаа, хайч, цавуу, бүртгэлийн хуудас гэх мэт).
- Бүртгэлийн хуудас бэлдэнэ. Үүнд: Хамтарсан багийн гишүүний овог нэр, аль бүлгийн төлөөлөл болох, холбоо барих утасны 1-2 дугаар, цахим хаяг, нас, хүйсийг тэмдэглэнэ.

Ойлголт нэгтгэх семинар зохион байгуулах зааварчилгаа

Хамтарсан багийн семинар

(Загвар хөтөлбөр)

Зорилго: “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ыг хэрэгжүүлэх хамтарсан багийн гишүүдийн ойлголтыг нэгтгэнэ.

10:00-10:20	Бүртгэл, нээлт, танилцах цаг
10:20-10:50	Дасгал: Сайн сургуулийг хамтдаа төсөөлцгөөе!
10:50-11:20	ПиПиТи танилцуулга: Сайн сургуулийг дэмжих аргачлал
11:20-11:50	Видео танилцуулга: “Сайн сургуулийг бүтээцгээе!” иргэний нийгмийн залуусын бүтээл
11:50-12:10	Дасгал: ССДА-ын зарчим, зорьж буй үр дүн
12:10-12:40	Төлөвлөлт: ССДА-ыг хэрэгжүүлэх хугацаа, ажил үүргийн хуваарь
12:40-13:00	Дүгнэлт

Семинарын хөтөлбөрийн зааварчилгаа

Бүртгэл: Семинар эхлэхийн өмнө багийн гишүүдээ бүртгэлийн хуудсын дагуу бүртгэнэ.

Нээлт:

- Сургуулийн удирдлага, хамтарсан багийн гишүүд, СЭЭБХ хамтран “Сайн сургуулийг дэмжих аргачлал”-ыг зохион байгуулах болсон тухай мэдээлэл өгнө.
- Энэхүү аргачлалыг хэрэгжүүлэхэд сургуулийн олон талт төлөөлөл нэг баг болон ажиллана.
- Иймд энэ хамтарсан баг нь аргачлалыг хэрэгжүүлэхээсээ өмнө хагас өдрийн семинар зохион байгуулж, ойлголтоо нэгтгэх шаардлагатайг тайлбарлана.

Танилцах цаг:

Хамтарсан багийн гишүүд цаашид хамтран ажиллахад бие биенээ сайн мэддэг байх хэрэгтэй. Иймд хөгжилтэй, сонирхолтой аргаар танилцах нь чухал учир дараах аргуудаас аль нэгийг нь ашиглан танилцаарай.

1. Чиглүүлэгч: Бүх оролцогчдыг тойрог болгон зогсооно. Эхний хүн өөрийгөө илэрхийлсэн ямар нэгэн үйлдэл хийгээд нэрээ хэлнэ. Дараа нь бүх оролцогчид түүний хөдөлгөөнийг дуурайн хийж нэрийг нь хэлнэ. Энэ мэтчилэн үйлдлийг давтаж хийсээр сүүлийн хүн хийж дуусмагц чиглүүлэгч-1-2 хүний хөдөлгөөнийг давтан хийж оролцогчдоор нэрийг нь таалгана. Ингэхийн тулд чиглүүлэгч оролцогчдыг өөрийгөө илэрхийлсэн хөдөлгөөн хийж нэрээ хэлэхийг нь сайн анхааралтай ажиглаж тогтооно.
2. Чиглүүлэгчид нэг бөмбөг байна. Чиглүүлэгч бөмбөгөө барьж зогсоод хамгийн түрүүнд өөрийгөө танилцуулна. Танилцуулахдаа өөрийнхөө нэрийг, хобби, хамгийн сайн хийж чаддаг зүйлийнхээ хамт хэлнэ. Яг энэ дарааллаар бусад оролцогчид өөрийгөө танилцуулна гэдгийг сануулна. Бөмбөгийг хэн рүү ч шидэж магадгүй тул бүх оролцогчид анхааралтай байх хэрэгтэй.

Дасгал: Сайн сургуулийг хамтдаа төсөөлцгөөе!

Зорилго:

Сайн сургуулийг дэмжих аргачлалыг хамтарсан баг хэрхэн хэрэгжүүлэх тухай нэгдсэн ойлголттой болно.

Бэлтгэл:

Самбарын цаас, өнгийн цаас, өнгийн харандаа, хайч, цавуу, скоч, маркер

Хугацаа: 30 минут

Зааварчилгаа:

1. Бүх оролцогчдыг 1, 2, 3-р тоолуулан гурван багт хуваана. Баг бүрт самбарын цаас болон өнгийн харандаа, өнгийн цаас хайч, цавуу зэргийг тарааж өгнө.
2. Чиглүүлэгч: “Та бүхний төсөөлдөг, мөрөөддөг сайн боловсрол, сайн сургууль гэж ямар сургуулийг хэлэх вэ? Таны бодлоор сайн боловсрол, сайн сургуулийг зургаар үзүүлбэл ямар өнгө будагтай яаж харагдах бол? Та бүхэн багаараа ярилцаад өмнөө байгаа

материалыг ашиглан зургаар илэрхийлнэ үү. Өөрийнхөө сургуулийн тухай, өөрийнхөө сургуулийг “ийм байгаасай” гээд зурж болно” гэдгийг тайлбарлана.

3. Баг бүр зурсан зургаа тайлбарлаж, сайн боловсрол сайн сургуулийн тухай бодлоо бусадтай хуваалцана. Чиглүүлэгч аль болох хүн болгон тайлбарлагчийн ярианд анхаарлаа хандуулахад дэмжлэг үзүүлнэ. Ялангуяа сурагчийн яриаг багш нар, томчууд анхаарахгүй, хоорондоо ярих зэрэг нь элбэг тохиолдоно. Ийм байдал гаргахгүй байхад анхаараарай.
4. Багаар хэлэлцэнэ. Чиглүүлэгч баг бүрийн зурсан зураг өөр өөрийн гэсэн онцлогтой сайн байсан тухай дурдаад чиглүүлэх асуултууд тавих замаар оролцогчдыг засаглалын болон сэтгэл зүйн орчны хэсэг рүү хөтөлнө. Чиглүүлэх асуултууд:
 - *Бидний харсан нийтлэг асуудал юу байсан бэ?*
 - *Багш нарын хувьд ямар асуудлыг илүү их гаргаж ирэв?*
 - *Сурагчид ямар асуудалд илүү анхаарсан бэ?*
 - *Эцэг эхийн хувьд аль асуудалд анхаарав?*
 - *Та бүхний зурсан зурганд сэтгэл зүйн орчны асуудал хэр их гарч ирсэн бэ?*
 - *Засаглалын орчны тухай бид зургандаа хэр тусгасан бэ?*
 - *Засаглалын болон сэтгэл зүйн орчин яагаад зургуудад бараг гарч ирээгүй вэ?*
 - *Бид сайн боловсрол, сайн сургуулийг ерөнхийд нь материаллаг орчны хүрээнд нь хардаг юм биш биз?*
 - *Яагаад бид цогцоор нь буюу энэ гурван орчны хүрээнд харах хэрэгтэй вэ?*

Видео танилцуулга:

“Сайн сургуулийг бүтээцгээе!” иргэний нийгмийн залуусын бүтээсэн богино хэмжээний кино үзүүлнэ. Киног CD эсвэл файлаар нь бэлэн байлгах, LCD дэлгэц, проектор, спикерийг урьдчилан бэлдсэн байна.

Дасгал: Сайн сургуулийг дэмжих аргачлалын зарчим, зорьж буй үр дүн

Зорилго:

Аргачлалыг хэрэгжүүлэх явцад баримтлах зарчим, зорьж буй үр дүнг ойлгуулна.

Бэлтгэл:

ССДА-ын зарчмуудыг оролцогчдын тоогоор нэг нэгээр нь хэвлэж бэлдсэн байна.

Заарварчилгаа:

1. Оролцогч бүрт нэг зарчим өгч, уншаад өөрийн ойлгож байгаагаар тайлбарлахыг хүснэ.
2. Оролцогчид нэгнийхээ тайлбарлахыг анхааралтай сонсон, нэмэх санаа байвал нэмж хэлж болно.
3. Оролцогчид бүгд тайлбарлаж дууссаны дараа чиглүүлэгч “та” зарчим бүрийг дахин тайлбарлана.

ПиПиТи танилцуулга:

Сайн сургуулийг дэмжих аргачлалын зорилго, бүтэц дараалал, засаглал, сэтгэл зүйн, материаллаг гурван орчны тухай танилцуулна. Өмнө нь энэ аргачлалыг хот, хөдөөгийн хэдэн сургууль дээр туршиж байсан, тэндээс гарсан сайн өөрчлөлт, сайн туршлагын тухай оролцогчдод товч мэдээлэл өгнө.

Төлөвлөлт:

Аргачлалыг хэрэгжүүлэх хамтарсан багийн ажлын төлөвлөгөөг дараагийн хуудаст өгөгдсөний дагуу гаргана.

Дүгнэлт:

Бүх гишүүдийн саналыг сонсон ярилцаж, ойлгоогүй, асуух зүйлс байгаа бол тодруулан ярьж дүгнэнэ. Хамгийн сүүлд үр дүнг нэгтгэж, сургууль дээр удирдлагын багийн зүгээс хийх ажлын саналыг хүргүүлж бусад талуудад танилцуулах ажлыг зохион байгуулахыг хэлж өгнө.